## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД 2022 ОНД АВЛИГА, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2023.01.18**

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|
| | **Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх** | | |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх. | 1.1.Хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилогдох албан тушаалтны Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлгийг АТГ-ын Дүн шинжилгээний хэлтэст хянуулж, томилох. | Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоог Төрийн албаны зөвлөлд танилцуулан тогтоол гарч, аймгийн салбар зөвлөлөөс ТЗ-6 ахлах 4 албан тушаалтныг томилохоор шийдвэрлэснийг АТГ-ын дүн шинжилгээний албаар хянуулахаар ХАСУМ-ыг хуулийн хугацаанд явуулсан байна.<br>Мөн БОЭТ-д шинээр томилогдох 9 ажилтаны ХАСУМ-ыг хуулийн хугацаанд хянуулан 7 томилуулж, 25 ажилтаны “Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг цахим хэлбэрээр мэдүүлж, хянуулан баталгаажуулж нийт 13 хүний ХАСУМ-ыг хянуулж ажилласан байна. |
| | | 1.2.Төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах, албан тушаалтнуудын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч АТГ-т тайлан, нэрсийг хуулийн хугацаанд хүргүүлэх. | Эрүүл мэндийн салбарын нийт 26 албан хаагч ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд цахим системд мэдүүлгийг гаргаж төв ЭБАТ-д хүргүүлж, бичмэл тайланг гарган хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллааа. |
| | | 1.3.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон сурталчилгааны самбар, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах. | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд тухайн байгууллагууд вэб сайт болон цахим хуудсандаа байршуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн газар Or.mohs.go.mn веб, Орхон эрүүл мэндийн газар цахим хуудас, зурагт хуудас зэргээр БОЭТ ww.orkhonboet.mn веб хуудас болон гарын авлага, самбар зэрэгт тус тус байршуулан мэдээллийн урсгалаар иргэдийг ханган ажиллаж байна.<br>Авлигын эсрэг сургалт, сурталчилгааны материалыг БОЭТ-ийн тасгуудад тараах соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулах. |

| | | | |
|---|---|---|---|
| | | |    <br>Мөн АТГ-аас ХАСХОМ гаргалтын талаарх шторк, сурталчилгааг ЭМГ-ын вэб хуудас болон сайтанд байршуулан сурталчилж байна. |
| | | 1.4. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор ажилчдад зориулсан сургалтын ажлыг зохион байгуулах | Ажилчдын Эрх зүйн мэдлэгийг сайжруулах ажлын хүрээнд:<br>**“Төрийн байгууллагын соёл, төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй”** сэдвээр Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Удирдлага сэтгэл зүйн тэнхимийн багш /Доктор , профессор/ Ч.Санжмятав, /Доктор, дэд профессор/ Б.Хэрлэн, Аймгийн Засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын байнгын хорооны дарга А.Бумансор нарын заасан хичээлд удирдлагын баг болон эмч 28, сувилагч 96, үйлчлэгч 25, бусад 11 ажиллагсад цахимаар оролцсон. **“Эмнэлгийн мэргэжилтний эрх зүйн хамгаалалтын үндсэн асуудал ба ёс зүй”** сэдэвт сургалтыг 2021 оны 11 сарын 11-д “Соёлыг түгээе” сарын аяны хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулан зохион байгуулсан. Тус сургалт Хүүхэд залуучуудын театрт зохион байгуулагдаж Анагаах ухааны доктор, дэд профессор нар Авлигын эсрэг шинэчилсэн хууль, дүрэм, ёс зүйн чиглэлээр хичээл зааж БОЭТ-ийн 42 их эмч, 76 сувилагч, 13 үйлчлэгч нийт 131 ажилтан оролцсон.<br><br>“**Авлигын эсрэг хууль”, “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”**-ийн талаар Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтанд 10 их эмч, 26 сувилагч 19 бусад ажилтнууд хамрагдсан. |

| | | | |
|---|---|---|---|
| | | |    |
| | | 1.5. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдэнд үйлчилгээ үзүүлж буй бүх түвшний мэргэжлийн болон захиргааны байгууллага, албан тушаалтнуудад зориулсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах. | Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 4216 хүн, 412 хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлж, тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/156 тоот захирамжийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжиж тайлант хугацаанд 403 хүүхдийн /сунгалт 316, шинээр 87/ асуудлыг шийдвэрлэж, боловсрол эрүүл мэндийн бусад үйлчилгээнд 32 хүүхдийг хамруулсан байна.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/124 дүгээр захирамжаар Хөгжлийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | бэрхшээлтэй хүүхдүүдийн сэргээн засах төвүүдийн үйл ажиллагааг дэмжиж 183 сая төгрөг, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй асран хамгаалагчдыг эрүүл мэнд, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах зардалд 55,0 сая төгрөг шийдвэрлэсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг сэргээн засах, хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргатай Найдвар төв, Пондолой аутизмын төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүдийн холбоо хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийг дэмжих төвийн байранд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааг шилжүүлж 7 хоног бүрийн Пүрэв гаригт үйл ажиллагааг явуулж хэвшсэн. |
| 2 | Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуур болон албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дээшлүүлэх | 2.1.Албан түшаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах. | Төрийн захиргааны албан тушаалын 11 сул орон тооны мэдээллийг Төрийн албаны салбар зөвлөлийн сайтад нээлттэй байршуулж, төрийн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулах захиалгыг Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж, шалгалтад орон иргэдийг мэдээллээр хангаж ажилласнаар 7 төрийн захиргааны албан хаагчийг ажлын байраар хангасан. Мөн төрийн үйлчилгээний албан хаагчдын сул орон тооны зарыг www.or.mohs.gov.mn www.orkhonboet.mn, орон нутгийн “Мэдээллийн бирж” телевиз, Эрүүл мэндийн хөгжлийн төв /https://old.hdc.gov.mn/account s.php/, АШУҮИС-ийн “Дотрын эмч нар”-ын сайтуудад ил тод нээлттэй байршуулж, шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтнийг авч ажиллуулсан.<br>БОЭТ нь байгууллагын хэмжээнд нэн шаардлагатай ажлын байр, дутагдалтай байгаа сул байгаа ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байгууллагын сайт/www.orkhonboet.mn сайтны “Хүний нөөц” цэсний Нээлттэй ажлын байр хэсэгт/, “Мэдээллийн бирж”, ЭМХТ-ийн төв /https://old.hdc.gov.mn/account s.php/, Эрүүл мэндийн газар”-ын сайт, АШУҮИС-ийн “Дотрын эмч нар”-ын сайтуудад ил тод нээлттэй тавьж байршуулсан.<br>Орхон аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуулийн дагуу улирал бүр шинээр ажилд орсон хүмүүс, шинээр бий болсон ажлын байр, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг өгсөн<br>• Хэрэгцээтэй байгаа нарийн мэргэжлийн их эмч, сувилагчийн оронд өндөр насны тэтгэвэрт гарсан 6 /нярай, сэргээн засахын 2 их эмч, хавдарын хими эмчилгээ, вакцин, ариутгал, эрчимт эмчилгээний 4 сувилагч, / ажилтантай гэрээ байгуулан тасралтгүй байдлын ханган ажиллаж байна.<br>Амбулатори, Дотор, Хүүхэд, ИТТ, Эмчилгээний хоол, лабортаори, Яаралтай тусламжийн тасгуудад гарсан их эмч, сувилагчийн сул орон тоон дээр зар тавин нийт 8 их эмч , 7 сувилагч, 8 үйлчлэгчийг шинээр ажилд авсан. |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>

</td></tr>
<tr><td></td><td></td><td>2.2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, өргөдөл, гомдлыг судалж тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</td><td>2022 онд байгууллагын ёс зүйн салбар хороонд Амбулатори, Дүрс оношилгооны тасгийн 2 их эмч, Амбулаторийн цаг товлолын 1 ажилтан дээр нийт 3 ажилтны өргөдөл ирснийг хянан хэлэлцэж эвлэрүүлэн зуучилсан.<br>Ирсэн нийт өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархалын агуулга
<table>
<tr><th>Агуулга</th><th>Тухайн байгууллагад ирүүлсэн нийт, өргөдөл, гомдол</th><th>хариу өгсөн</th></tr>
<tr><td>Цаг товлолт, цаг ашиглалт, хүлээгдэл, чирэгдэл<br>
• Зүрх судасны эмчид үзүүлэх цаг дууссан –4<br>
• Мэдрэлийн эмчид үзүүлэх гэхээр үзлэг ихтэй хүлээгдэлтэй байна.<br>
• Мэс засал<br>
• Ахмадын эмчийн ажлын цаг ашиглалтыг сайжруулах-2<br>
• Түргэн тусламжийн дуудлага хүлээгдэж байна.<br>
• Цаг товлох үйлчилгээг сайжруулах-19<br>
• Боолтонд цаг авсан боловч цаг ороогүй байна гээд буцаасан.<br>
• Хэвтэн эмчлүүлэгчийг 1 л эмч эход харж байгаа нь хүлээгдэлтэй байна.<br>
• Хэвтэн эмчлүүлж байх хугацаанд нь нүдний эмчид үзүүлэх гээд чадсангүй<br>
• Эрүүл мэндийн хуудас бөглүүлэх мэдээлэл муу өгснөөс нэг эмч дээр 3 удаа очиж байна.<br>
• Шинжилгээ өгөх гэхээр тэр шинжилгээг өгөх шаардлагагүй гээд илгээж өгөхгүй байна.<br>
• Рентген техникч нь ажилдаа цагтаа ирэхгүй байна.</td>
<td>-өөрийн биеэр-4<br><br>-70353511 дугаарын утсаар-24<br>- 77000040 дугаарын утсаар-5<br>- бичгээр-1<br>-1111 дугаарын утсаар-1</td>
<td>35</td></tr>
</table></td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Рентген техникч урдуур хүн оруулаад байна.<br>өөрийн биеэр-2<br>- 70353511 дугаарын утсаар-5<br>- бичгээр-2 | | |
| | | | Эмнэлгийн гадаад, дотоод орчны зохион байгуулалт, аюулгүй байдал<br>- E clinic машинтай холбоотой-2<br>- - Эмнэлгийн дуугүй хөтөч шаардлага хангахгүй, хөтөч нар нь үйлчилгээ үзүүлж чадахгүй, ямар ч зохицуулалт алга<br>БОЭТ-ийн касс интернет банк болон картаар тооцоо хийдэггүй зөвхөн бэлэн мөнгөөр хийж байгаа нь хүндрэлтэй байна. | -70353511 дугаарын утсаар-6 | 6 |
| | | | Байгуулагын соёл, харилцаа хандлага | -70353511 дугаарын утсаар-5<br>-Өөрийн биеэр-5<br>- бичгээр-2 | 12 |
| | | 2.3.Эмч, эмнэлгийн ажилтнуудын ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийн шалтгаан, нөхцлийг тогтоон арилгах, тайлагнах хэлэлцүүлэх ажлыг хийж хэвших | Тайлант хугацаанд БОЭТ-өөр үйлчлүүлсэн хэвтэн эмчлүүлэгч болон амбулаториор тусламж үйлчилгээ авсан иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хоёр янзын аргаар авч боловсруулаа.<br>“Цахим үндэстэн” хөтөлбөрийн хүрээнд судалгааг QR кодыг ашиглан Google form sheet дээр үр дүнг боловсруулаа. Нийт оролцсон 290 хүний 45 хүн уламжлалт арга буюу цаасан хэлбэрээр судалгаанд оролцсон бол үлдсэн 245 нь цахимаар оролцсон байна.<br>**НЭГ.АМБУЛАТОРИЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА**<br>Судалгааг ЭМС-ын 2021 оны А/578 тоот тушаалыг үндэслэн 32 асуултаар авсан судалгаанд 2022 оны I хагас жилд нийт-91 үйлчлүүлэгч хамрагдсан. Бичгэн хэлбэрээр буюу цаасан дээр судалгаа бөглөж оролцсон 45 иргэдийн судалгааг SPSS программ дээр судалгааг боловсруулж дүгнэлт хийлээ. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 37 /82,2%/ эмэгтэй, 8 /17,8%/ эрэгтэй үйлчүүлэгч байсан.<br>I. **Эмнэлгийн мэргэжилтний харьцаа, хандлага тусламж үйлчилгээний чанар-** 72,2% сайн, маш сайн<br>2021 оны II хагаст **–** маш сайн-47%, сайн 24,6% гэж хариулсан нь 2021 оноос 19,7%-иар сайжирсан.<br>**ХОЁР. ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА**<br>2021 оны хоёрдугаар хагас жилд ЭМС-ын 2021 оны А/578 тоот тушаалыг үндэслэн 32 асуумжаар 12 тасгийн 199 хэвтэн эмчлүүлэгчээс судалгаа авав.<br>2021 оны II хагас: маш сайн 55,8%, сайн 26,1% бол 2022 оны 1-р хагаст<br>1. Эмч болон эрүүл мэндийн ажилчидын харилцаа хандлагатай холбоотой-5 /11,1%/<br>➢ Мэдэхгүй зүйлсээ асуухад хариулдаггүй-1<br>➢ Төрөх, эмэгтэйчүүдийн тасгийн эмч сувилагч нар харилцаандаа анхаарах-1<br>➢ Нярайн тасаг харилцаандаа анхаарах-1 | | |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ➢ Эмч нар нь цагтаа орж ирж үзлэг үр дүнтэй хийх-1<br><br>Эмч, эмнэлгийн ажилчидад талархал, саашаал ирсэн 15 буюу /34,8%/ ирсэн байна. |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах. | 3.1.Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, ААНБ болон гадаадын хандив, зээл тусламжийн ил тод байдлыг хангаж ажиллах. | Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль”, “Эрүүл мэндийн тухай” хууль, “Авлигын эсрэг хууль”, “ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хуулиуд болон эрүүл мэндийн салбарын бусад хууль тогтоомжууд, үндэсний стратеги, Монгол улсын Засгийн газрын тогтоол, шийдвэр, Аймгийн ИТХ–ын тогтоол, Засаг даргын захирамж, ЭМГ,БОЭТ тушаалууд зэргийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, хууль, дүрэм журам, тушаал зааврын талаарх цаг үетэй холбоотой мэдээллийг Хүний нөөц, гадаадын зээл тусламжийн мэдээллийн ил тодын самбарт болон байгууллагын **or.mohos.go.mn** вэб хуудас болон цахим хуудсанд тухай бүрд нь шинэчлэн байршуулж мэдээллээр ханган ажиллаж байна.<br><br> |
| 4 | | 4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад хяналт тавих, | Төсвийн тухай хууль, ЭМС-ын тушаалаар батлагдсан журмын хүрээнд ТБОНӨБАҮХАТ хуулийн дагуу 2022 онд Эм эмнэлгийн хэрэгсэл урвалж оношлуур худалдан авах нээлттэй тендерийг БОЭТ-ийн захирлын 2022 |

| | | | |
|---|---|---|---|
| | Хяналт хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх. | | оны 01 сарын 07 өдрийн А/02 тоот тушаалаар баталж тендерийн урилгыг 2022 оны 01-р сарын 21-ны өдрийн өдөр тутмын Өнөөдөр сонин,UB post сонин,Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтуудаар тус тус нийтлэгдсэн.2022 онд Эм эмнэлгийн хэрэгсэл,урвалж оношлуур худалдан авах тендерт нийт 45 багцад 28 компани оролцсоноос 20 компанитай 2021 оны 03-р сарын 07-ны өдөр хамтран ажиллах гэрээ байгуулна.03-р сарын 07-ноос тендерийн хуваарийн дагуу нийлүүлэлт хийгдэнэ. Тендерт нийт 45 багцаас 42 багцад нь компани шалгарсан бөгөөд 3 багцад компани ороогүй дахин тендер 03-р сарын 10-нд зарлагдсан.<br>БОЭТ-ын захирлын 2022 оны 01 сарын 07 ны өдрийн А/02 тоот үнэлгээний хорооны тушаалаар Хүнсний материал болон түлш шатахуун нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалт 3 багцад зарлан хуулийн дагуу үнэлгээ хийгдсэн. 2,3-р багцад Баясгалант Бат-Очир ХХК, Баян хөхийн элч ХХК компаниуд шалгарч гэрээ байгуулан хүнсний материалын аюулгүй байдлыг ханган бараа бүтээгдэхүүнээр хангаж байна. 1-р багцад материал ирүүлээгүй учир харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулан хуулийн дагуу Мах маркет ХХК- тай хамтран ажиллах гэрээ байгуулан бараа материалаар ханган ажиллаж байна.<br><br>Шатах тослох материалын тендерт шаардлага хангасан "НИК " ХХК –тай хамтран ажиллах гэрээ байгуулан хуваарийн дагуу нийлүүлж байна. Бусад бараа материалын худалдан авалтууд худалдан авах ажиллагааны цахим хуудсанд нээлттэй мэдээлэгдэн үнийн саналаар шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. |
| | | 4.2.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхижүүлэх, хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг мэдээлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийн сар, улирлаар гарган анхан шатны эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын цахим систем, Эрүүл мэндийн газрын вэб сайтад ил тод байршуулсан. Эрүүүл мэндийн салбарын шуурхайд улирал тутам статистик үзүүлэлтийг танилцуулан эргэн мэдээллээр ханган ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ын дагуу Эрүүл мэндийн газраас нэгтгэгдэн гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2022 оны хагас болон жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад албан хаагчдыг зөвлөмжөөр ханган тайланд тухай бүр сайжруулалт хийж, илтгэх |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хуудас, зөвлөмжийг албан хаагч тус бүрд хүргэн ажилласан. Нийт 28 тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдсэн. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тухай Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын тамгын газарт албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн.<br>Байгууллагын Дотоод хяналтын багийг шинэчлэн байгуулах тухай Эрүүл мэндийн газрын даргын А/44 дүгээр тушаал, 2022 оны төлөвлөгөөг батлуулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна. Тайлант хугацаанд нийт 11 хяналт хийснээс төлөвлөгөөт 8, төлөвлөгөөт бус 3 хяналтыг хийж дүгнэлтийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох албан хаагчдад хяналтын дүнг танилцуулан зөвлөмжөөр ханган ажилласан.<br>Төрийн аудитын газраас 2021 оны санхүүгийн тайланд хяналт, шалгалт хийгдэж 1 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт тавигдсанаас дээрх зөрчил дутагдлыг бүрэн арилган, албан бичгээр нотлох баримтын хамт хүргүүлсэн. Мөн 2021 оны санхүүгийн тайланд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдэж 5 зөвлөмж, 2 албан шаардлага, 2 төлбөрийн акт тавигдсанаас зөрчлийг арилгасан тухай албан бичиг, нотлох баримтын хамт хүргүүлж илэрсэн алдаа дутагдлыг бүрэн арилгасан. |

Биелэлт гаргасан: ЭБАТ Д.ОТГОНДЭЛГЭР